

ЭРСДЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2016 оны удирдлага,
санхүүгийн үйл ажиллагаа**

*Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг хууль, дүрмийн дагуу зохион байгуулаагүй,
төсвийн гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс төсвийг зориулалт бусаар,
үр ашиггүй зарцуулсан байна.*

Сүхбаатар 2017 он

Тайланг бэлтгэсэн:

**Сэлэнгэ аймаг дахь
Төрийн аудитын
газар**

Дарга, Тэргүүлэх аудитор

Ч.Энхтуяа

Аудитын менежер

Б.Батмөнх

Аудитор

Ц.Отгонбаяр

2017 оны 09 дүгээр сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70363036 дугаарын утсаар
холбоо барина уу.

ХАЯГ:

Сэлэнгэ аймаг

Сүхбаатар хот

Аймгийн ЗДТГ-ын

өргөтгөлийн 2-р давхар

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар 3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4

Аудитын дүн.....5-11

Бүлэг 1. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үндсэн үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

1.1 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаа хууль, дүрмийн дагуу зохион байгуулагдан, явагдаж байна уу?

1.2 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөгдөж байгаа эсэх?

Бүлэг 2. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа холбогдох хууль, стандартын дагуу явагдаж байна уу?

2.1 Санхүүжилтийг журмын дагуу төлөвлөж, зарцуулж байгаа эсэх?

2.2 Нягтлан бодох бүртгэлийг хууль, стандартын дагуу хөтөлж, тайлагнаж байна уу?

Илрүүлсэн зөрчил.....12

Дүгнэлт.....12

Зөвлөмж.....12-13

Холбогдох байгууллагын санал:

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал

.....
Саналд өгсөн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

ЭА	Эрсдэлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ББН	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ЗНБ	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.Аудитын нэр:

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2016 оны удирдлага, санхүүгийн үйл ажиллагаа.

2.Аудитын код:

СЭА-2017/03/СТА-ЭА

3.Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

4.Аудитын зорилт:

Сүхбаатар, Мандал сумдын Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2016 оны удирдлага, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зарим эрсдэлтэй асуудлыг хамруулан шалгаж, дүгнэлт гарган, санал зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад эрсдэлийн аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв.Үүнд:

1. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үндсэн үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?
2. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа холбогдох хууль, стандартын дагуу явагдаж байна уу?

5.Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2016 оны үйл ажиллагаа, санхүүжилтийн төлөвлөгөө, тайлан, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтууд болон холбогдох бусад баримт материал, мэдээллийн эх сурвалжуудыг хамруулан шалгалаа.

6.Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС-3000-3001/-ийг ашиглан өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга, нягтлан бодогч, эд хариуцагч нартай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, тус байгууллагаас ирүүлсэн мэдээлэл, нотлох зүйлийг ашиглан түүнд судалгаа, шинжилгээ хийх, давтан шалгах зэрэг арга зүйг ашиглалаа.

7. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Ц.Отгонбаяр 2017 оны 09 дүгээр сарын 06-аас 10 дугаар сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

8. Үндсэн мэдээлэл

Тайлант онд Сүхбаатар сумын Зөвлөх ӨЭМТ 6553 иргэнд 83,396.8 мянган төгрөгийн, Номтхан ӨЭМТ 6008 иргэнд 78,739.0 мянган төгрөгийн, Хаданхуй ӨЭМТ 5677 иргэнд 72109.7 мянган төгрөгийн, Эмнэх ӨЭМТ 4431 иргэнд 59,264.2 мянган төгрөгийн, Мандал сумын Бату ӨЭМТ 6518 иргэнд 96955,2 мянган төгрөгийн, Баянбаг

ӨЭМТ 6614 иргэнд 89,180.2 мянган төгрөгийн, Ачит ӨЭМТ 5434 иргэнд 81,101.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаар гэрээ байгуулан ажилласан байна.

АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үндсэн үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шинэчилсэн дүрмийн дагуу зохион байгуулж, үйл ажиллагааны үр дүнг тухай бүр дүгнэж ажиллах шаардлагатай байна.

1.1 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаа хууль, дүрмийн дагуу зохион байгуулагдан, явагдаж байна уу?

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг хууль, дүрмийн дагуу зохион байгуулаагүй байна.

2011 онд шинэчлэн, батлагдсан Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2-д “Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна” гэж заасан байдаг.

Эрүүл мэндийн сайдын 2011 оны 304 дугаар тушаалаар өрхийн эмнэлгийг өрхийн эрүүл мэндийн төв болгон өөрчлөн зохион байгуулжээ.

Засгийн газрын 2011 оны 364 дүгээр тогтоолоор баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 1.3-д “Төв нь нөхөрлөл хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд байна. Төвийг нийслэл, аймгийн төв болон нэгдсэн эмнэлэг бүхий бусад суурин газарт байгуулна” гэж заасны дагуу Сүхбаатар суманд 4, Мандал суманд 3 өрхийн эрүүл мэндийн төв /ӨЭМТ/ нөхөрлөл хэлбэрээр зохион байгуулагдсан байна.

Засгийн газрын 2011 оны 364 дүгээр тогтоолын 2 дахь ¹заалтаар нэг ӨЭМТ нь 6000-аас доошгүй иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэх ёстой боловч Мандал сумын Ачит ӨЭМТ 5434, Сүхбаатар сумын Эмнэх ӨЭМТ 4431, Хаданхуй ӨЭМТ 5677 иргэнд үйлчилж байна.

“Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.3² дахь заалт буюу “нийт эмч, мэргэжилтний 60-аас доошгүй хувь нь нөхөрлөлийн гишүүн байна” гэсэн заалтыг тулган баталгаажуулах зорилгоор аудитын явцад Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс ӨЭМТ-үүдийн нөхөрлөлийн гишүүдийн лавлагааг авч, одоо ажиллаж байгаа орон тоотой харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 1

¹ Өрхийн эрүүл мэндийн нэг төвд ногдох иргэний тоог нийслэлд 8000-аас , аймаг, суурин газарт 6000-аас доошгүй бөгөөд нийт ногдох иргэний тоо 14000-аас хэтрэхгүй байхаар тогтоосугай”

² Төв нь нөхөрлөлийн аль ч хэлбэрээр зохион байгуулагдаж болох бөгөөд нийт эмч, мэргэжилтний 60-аас доошгүй хувь нь нөхөрлөлийн гишүүнд хамрагдсан байна.

№	Сумын нэр	ӨЭМТ-ийн нэр	Нөхөрлөлд байгаа гишүүдийн тоо	Үүнээс одоо ажиллаж байгаа	2016 онд ажилласан эмч, мэргэжилтний тоо	Нөхөрлөлийн гишүүний эзлэх хувь
1	Сүхбаатар	Зөвлөх	3	1	3 их эмч, 2 сувилагч	20%
2		Эмнэх	3	1	3 их эмч, 2 сувилагч	20%
3		Номтхан	3	2	2 их эмч, 3 сувилагч	40%
4		Хаданхуй	2	1	3 их эмч, 2 бага эмч, 1 сувилагч	17%
5	Мандал	Бату	2	1	3 их эмч, 1 бага эмч, 3 сувилагч	14%
6		Баянбаг	3	1	3 их эмч, 4 бага эмч	14%
7		Ачит	4	1	3 их эмч, 2 бага эмч, 1 сувилагч	17%

Хүснэгтээс харахад нийт эмч, мэргэжилтний 60-аас доошгүй хувь нь нөхөрлөлийн гишүүн байна гэсэн заалтыг нэг ч ӨЭМТ хангахгүй байна.

Дээрх нөхөрлөлүүдийн зохион байгуулалтыг авч үзвэл Бату ӨЭМТ-өөс бусад нөхөрлөл нь бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай буюу ББН хэлбэрээр зохион байгуулагдсан байна.

Нөхөрлөлийн тухай хуулийн 2-р бүлэг “Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл”-ийн 26-р зүйлд³ “... аль нэг гишүүн нөхөрлөлөөс гарсан тохиолдолд нөхөрлөл татан буугдана.” гэсэн заалтын дагуу дээрх ӨЭМТ хэлбэрээр зохион байгуулагдсан нөхөрлөлүүд нь бүгд татан буугдах үндэслэлтэй болсон байна.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 01-р сарын 04-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан ӨЭМТ-ийн дүрмийн 1.6-д “Өрхийн эрүүл мэндийн төвд ногдох иргэний доод хязгаар 8000-аас доошгүй байна.”, 2.3.1-д “Төв нь нөхөрлөлийн аль ч хэлбэрээр зохион байгуулагдаж болох бөгөөд тухайн төвд ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний 70-аас доошгүй хувь нь нөхөрлөлийн гишүүнд хамрагдсан байна.” гэж дүрмийн заалтад өөрчлөлт оруулсныг хангаж байгаа ӨЭМТ байхгүй байна.

Иймд үйл ажиллагаа явуулж байгаа нөхөрлөлүүдийг татан буулгаж, нэгтгэх хэлбэрээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, хууль, дүрмийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй юм.

1.2 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөгдөж байгаа эсэх?

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2016 оны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, дүгнэлт өгөгдөөгүй байна.

³ Аль нэг гишүүн нөхөрлөлөөс гарсан, хасагдсан, хөрөнгийн чадваргүй болсон буюу нас барсан, сураггүй алга болсонд тооцоогдсон гишүүний өв залгамжлагч тухайн нөхөрлөлд ороогүй тохиолдолд нөхөрлөл татан буугдана. Гэхдээ тухайн нөхөрлөл цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулахаар бол гэрээгээ шинэчилж бүртгэх байгууллагад дахин бүртгүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 01-р сарын 07-ны өдрийн 2/48 дугаар албан бичгээр ӨЭМТ-ийн гүйцэтгэлийн гэрээг дүгнэх журмын төслийг хүргүүлж, уг төсөлд орон нутгийн онцлогийг тусган эцэслэн боловсруулж, аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулан, хэрэгжүүлж ажиллахыг даалгасан байна.

Үүний дагуу Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2014 оны 06-р сарын 11-ний өдрийн А/235 дугаар захирамжийн 1-р хавсралтаар өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээг дүгнэх ажлын хэсгийг, 2-р хавсралтаар өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээг дүгнэх журмыг, 3-р хавсралтаар “Шалгуур үзүүлэлт”-ийг тус тус баталсан байна.

Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээг дүгнэх журмын 2⁴ дахь заалтын дагуу бүх ӨЭМТ-үүд 2016 оны 2-р сард аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, Эрүүл мэндийн газрын даргын Ж.Од нартай гурвалсан гэрээг байгуулсан байна.

Дээрх журмын 4.1⁵-д “6.3⁶-д гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж, жилд 2 удаа дүгнэх бөгөөд 2 дүнгийн дунджаар жилийн эцсийн гэрээний дүнг гаргана” гэж заасан боловч ӨЭМТ-үүд 2016 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг зөвхөн жилийн эцэст тайлагнасан байна. Гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг үнэлж, дүгнэсэн эсэхийг аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн даргаар ахлуулсан ажлын хэсгээс тодруулахад “2016 онд улаанбурхан өвчний дээдэлт гарч, эрүүл мэндийн салбар эрсдлийн бэлэн байдалд ажиллаж, хүний нөөцийн хүрэлцээ дутмаг байснаас үнэлгээ хийгээгүй” гэсэн тайлбарыг албан бичгээр өглөө.

Цаашид өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг журамд заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлж, дүгнэн, хангалтгүй үнэлгээ авсан ӨЭМТ-ийн гэрээг цуцалж, дараагийн ӨЭМТ-ийг сонгон шалгаруулах зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа холбогдох хууль, стандартын дагуу явагдаж байна уу?

Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь нягтлан бодох бүртгэлийг хууль, стандартын дагуу хөтлөөгүй, зардлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс санхүүжилтийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна.

2.1 Санхүүжилтийг журмын дагуу төлөвлөж, зарцуулж байгаа эсэх?

ӨЭМТ-үүд санхүүжилтийг журмын дагуу төлөвлөсөн боловч төсвийн гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан байна.

Засгийн газрын 2011 оны 364 дүгээр тогтоолоор баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 3.2-д “Төсвийн санхүүжилтийг нэг иргэнд ногдох зардлаар тооцож олгоно” гэж заажээ.

Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 156/77 дугаар хамтарсан тушаалын 1-р хавсралтаар “Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийн төсөл

⁴ Гэрээг 1 жилийн хугацаатай тухайн оны 2-р сард багтаан байгуулна.

⁵ Гэрээний биелэлтийг шалгуур үзүүлэлтийн дагуу хагас жил тутамд 1 удаа, нийт 2 удаа дүгнэж, 2 дүнгийн дунжийг жилийн эцсийн гэрээний биелэлтийн дүн гэж тооцно.

⁶ Гэрээний биелэлтийг жил бүрийн зургаа, арван хоёрдугаар сарын 25-ны дотор багтаан дүгнэж, дүнг ажлын хэсгийн хурлаар хэлэлцсэн протокол, Илтгэх хуудас, саналын хамт аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газарт зургаа, арван хоёрдугаар сарын 30-ны дотор хүргүүлнэ.

боловсруулах, төсвийг хуваарилах, санхүүжүүлэх журам”-ыг, 2-р хавсралтаар “Өрхийн эрүүл мэндийн төвийн нэг иргэнд ногдох эрүүл мэндийн зардлын хэмжээ”-г тус тус баталсан байна.

Дээрх журмын дагуу 2016 онд ӨЭМТ-үүдийн санхүүжилтийг дараах байдлаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 2 /мянган төгрөгөөр/

№	Насны бүлэг	Оршин суугаа газар	Нэг иргэнээр тооцсон тариф	Эмнэх		хаданхуй		зөвлөх		Номтхан		Ачит		Батү		Баянбаг	
				хүн амын тоо	санхүү-жилт	хүн амын тоо	санхүү-жилт	хүн амын тоо	санхүү-жилт	хүн амын тоо	санхүү-жилт	хүн амын тоо	санхүү-жилт	хүн амын тоо	санхүү-жилт	хүн амын тоо	санхүү-жилт
1	0-5 нас	Гэр хороолол	26479.3	364	9,638.5	542	14351.8	727	19250.5	704	18,641.4	861	22798.7	785	20,786.3	801	21209.9
		байшин хороолол	23276.7	240	5,586.4		0	139	3235.5		-	88	2048.4	34	791.4	144	3351.8
2	6-15 нас	Гэр хороолол	11266.9	461	5,194.1	703	7920.6	748	8427.6	979	11,030.3	908	10230.3	1354	15,255.5	779	8776.9
		байшин хороолол	10466.3	409	4,280.7		0	149	1559.5		-	98	1025.7	15	156.9	265	2773.6
3	16-49 насны эмэгтэйчүүд	Гэр хороолол	12067.6	1396	16,846.4	1381	16665.4	1311	15820.6	1392	16,798.1	1128	13612.2	1925	23,230.2	1539	18572.1
		байшин хороолол	12067.6	514	6,202.7		0	248	2992.7		-	1040	12550.3	103	1,242.9	401	4839.1
4	60-аас дээш	Гэр хороолол	16871.5	150	2,530.7	511	8621.3	201	3391.2	544	9,178.1	798	13463.4	460	7,760.9	489	8250.2
		байшин хороолол	15270.1	98	1,496.5		0	59	900.9		-	97	1481.2	11	167.9	53	809.3
5	бусад	Гэр хороолол	9665.6	506	4,890.8	2540	24550.6	1849	17871.7	2389	23,091.1	254	2455.1	1663	16,073.9	1998	19311.9
		байшин хороолол	8,865.0	293	2,597.4		0	1122	9946.5		-	162	1436.1	168	1,489.3	145	1285.4
	Нийт дүн			4431	59,264.2	5677	72109.7	6553	83396.7	6008	78,739.0	5434	81101.4	6518	86,955.2	6614	89180.2

Хүснэгтээс харахад ӨЭМТ-үүдийн санхүүжилтийг журмын дагуу зөв тооцож, төлөвлөсөн байна.

ӨЭМТ-ийн үлгэрчилсэн дүрмийн 2.9 -д “ӨЭМТ-ийн дарга нь хөрөнгийн зарцуулалтыг хамт олны хурлаар хэлэлцүүлэн батлуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, хамт олныг мэдээллээр хангаж ажиллана” гэсэн боловч уг заалтыг нэг ч ӨЭМТ хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Сүхбаатар, Мандал сумын ӨЭМТ-ийн нягтлан бодогчид жилийн эцэст ӨЭМТ тус бүрээр төсвийн гүйцэтгэлийг тайлагнасан боловч удирдлагаар хянуулж, батлуулаагүй, хамт олны хурлаар хэлэлцүүлээгүй байна.

ӨЭМТ-үүд нь өөрийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэлгүйгээр 100 хувь төсвийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 2016 оны санхүүжилт болон зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /дэлгэрэнгүйг хавсралт 1,2-т үзүүлэв./

№	Зардлын эдийн засгийн ангилал	Эмнэх	Зөвлөх	Номтхан	Хаданхүй	Бату	Баянбаг	Ачит	Нэгтгэл
1	Санхүүжилт	59,263.2	83,396.4	78,738.0	72,112.0	86,955.2	89,180.2	81,101.5	550,746.5
2	Нийт зардлын дүн	59,263.2	83,396.4	78,738.0	72,112.0	86,955.2	89,180.2	81,101.5	550,746.5
3	Үндсэн цалин	48,640.4	65,727.7	60,639.5	60,677.7	66,354.4	68,796.8	63,457.0	434,293.5
4	Ажил олгогчоос төлөх НДШ	4,780.1	7,196.6	6,619.8	6,694.6	7,160.7	7,592.3	6,500.7	46,544.8
5	Тогтмол зардал	-	-	3,931.8	2,366.5	3,752.7	3,493.7	4,453.6	17,998.3
6	Гэрэл, цахилгаан	-	-	263.4	1,356.5	298.8	300.7	4,453.6	6,673.0
7	Түлш, халаалт	-	-	2,754.8	1,010.0	3,129.8	3,083.1	-	9,977.7
8	Цэвэр бохир ус	-	-	913.6	-	324.1	109.9	-	1,347.6
9	Хангамж, бараа материалын зардал	2,164.7	3,330.6	2,789.0	1,535.1	3,857.0	3,141.2	3,057.8	19,875.4
10	Бичиг хэрэг	449.2	1,100.9	765.5	142.8	1,414.2	801.0	1,238.3	5,911.9
11	Тээвэр, шатахуун	800.0	720.0	860.0	680.0	1,154.2	1,077.1	1,375.8	6,667.1
12	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	540.8	950.8	673.6	637.4	638.6	330.7	443.7	4,215.6
13	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	374.7	558.9	489.9	74.9	650.0	932.4	-	3,080.8
14	Нормативт зардал	641.4	1,611.1	754.6	21.9	1,695.8	1,268.0	1,114.1	7,106.9
15	Эм	641.4	1,100.1	506.6	21.9	1,261.6	904.6	973.2	5,409.4
16	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	511.0	248.0	-	434.2	363.4	140.9	1,697.5
17	Эд хогшил, урсгал засварын зардал	229.9	2,351.8	496.0	-	1,452.0	2,459.0	678.5	7,667.2
18	Багаж,техник,хэрэгсэл	-	820.0	85.0	-	-	-	-	905.0
19	Тавилга	229.9	1,200.0	-	-	472.0	220.0	-	2,121.9
20	Урсгал засвар	-	331.8	411.0	-	980.0	2,239.0	678.5	4,640.3
21	Томилолтын зардал	632.8	103.8	147.3	81.4	980.7	781.6	503.6	3,231.2
22	Бусад зардал	2,173.9	3,074.8	3,360.0	734.8	1,701.9	1,647.6	1,336.2	14,029.2

Хүснэгтээс харахад 2016 онд ӨЭМТ-үүдийн үйл ажиллагаанд зориулан орон нутгийн төсвөөс нийт 550,746.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосны 85-90 хувийг цалингийн зардалд зарцуулсан байна.

ӨЭМТ-үүдийн санхүүжилтийн зарцуулах эрхийг Сангийн яам болон төрийн сан 1 иргэнд ногдох нормативаар тооцсон бараа, үйлчилгээний бусад зардал гэсэн ангилалд зардлын зүйл, бүлгээр бус бөөн дүнгээр хянаж, батлан, тайлагнуулж байгаа нь зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг сулруулж байна.

Өөрөөр хэлбэл, нэгэнт төсвөөс 100 хувь санхүүжүүлж буй зардлын гүйцэтгэлийг бүлгийн дүнгээр, зардлын зүйлээр төлөвлөж, батлах, хянах тогтолцоо бүрдээгүй нь ӨЭМТ-үүд төсвөөс олгосон санхүүжилтийг хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа хийх, эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх зэрэг үндсэн зорилгоос гадна өөрсдийн үзэмжээр, зориулалт бусаар зарцуулах эрсдлийг үүсгэж байна.

Аудитын явцад ӨЭМТ-үүдийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай нь тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Мандал сумын ӨЭМТ-үүд:

- Ачит ӨЭМТ-ийн дарга, их эмч О.Мөнхзулд 1 жилийн цалинтай чөлөөтэй байх хугацаанд ээлжийн амралтын олговор 460.4 мянган төгрөгийг олгосон нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1-р

хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 9⁷-ийг зөрчсөн байна.

- Мандал сумын ӨЭМТ-үүдийн нягтлан бодогч Н.Элбэгзаяа нь Бату ӨЭМТ-өөс 3-р сард цалингийн урьдчилгаа авч, тооцооны дансаар дамжуулж бүртгээгүйгээс жилийн эцэст 426.9 мянган төгрөг дутуу суутган, авлага үүсгээгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁸, 14.4.2⁹ дахь заалтыг зөрчсөн байна.
- Бату ӨЭМТ нь тайлант хугацааны цалингийн зардлыг татварын тайланд 3,020.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, 315.7 мянган төгрөгийн, Ачит ӨЭМТ нь 5507.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, 526.8 мянган төгрөгийн татварын өглөг тус тус үүсгэсэн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 28-р зүйлийн 28.1 , Төсвийн тухай хуулийн 6.4.8 гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Сүхбаатар сумын ӨЭМТ-үүд:

Тус сумын ӨЭМТ-үүд нь Засгийн газрын 2010 оны 108 дугаар тогтоолыг зөрчиж, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 5 хувиар илүү тооцож олгосон байна. Тодруулбал:

- Хаданхуй ӨЭМТ нь 1 их эмчид 333.3 мянган төгрөгийг,
- Зөвлөх ӨЭМТ нь 2 их эмчид 850.2 мянган төгрөгийг,
- Номтхан ӨЭМТ нь 2 их эмч, 1 сувилагчид 984.5 мянган төгрөгийг зэрэг нийт 2,168.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Сүхбаатар сумын ӨЭМТ-үүд нь одоо ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтнуудыг нөхөрлөлийн гишүүнд элсүүлээгүй атал хамт олны хурлаар хэлэлцсэн гэх шалтгаанаар дуртай үедээ өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн дотоод журамд хууль, эрх зүйн үндэслэлгүйгээр нэмэлт өөрчлөлт оруулан төсөв, хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байна. Тодруулбал:

- Эмнэх ӨЭМТ нь Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 3-р хавсралтыг зөрчиж, дотоод журмын 9.2-д “Эрдмийн цол, магистр болон ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэгтэй эмчид 20 %, сувилагч нарт 15 % нэмэгдлийг сар бүр цалинд нь нэмж олгоно” гэсэн заалт оруулж, тус төвийн дарга П.Баянжаргал эмчид магистрийн зэргийн нэмэгдлийг 20 хувиар тооцож 1,161.9 мянган төгрөгийг,
- Зөвлөх ӨЭМТ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1¹⁰ дэх заалтыг зөрчиж, дотоод журмын 7.5-д “тус ӨЭМТ-д тасралтгүй, тогтвор суурьшилтай, 15-аас дээш жил ажиллаж байгаа ажилтны үр хүүхэд, их дээд сургуульд элсэн орж, суралцсан тохиолдолд тухайн жилийн төсөв санхүүжилтыг харгалзан сургалтын төлбөрийн 30-50 хувийг өрхийн эрүүл мэндийн төвөөс гаргана.” гэсэн заалт оруулж, тус төвийн дарга Д.Энхтүвшингийн хүүхдийн сургалтын төлбөрт 50 хувиар тооцож 1,575.0 мянган төгрөгийг тус тус олгосон байна.
- Зөвлөх ӨЭМТ нь холбооны зардалд 148,5 мянган төгрөгийг илүү шилжүүлснийг авлага үүсгээд, санхүүгийн тайланд тусгаагүй байна.

⁷ Цэргийн жинхэнэ алба хаасан, тэтгэмжтэй чөлөөтэй байсан, техникийн мэргэжлийн сургуульд суралцсан, 6 сараас дээш хугацаагаар мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхээр суралцсан хугацаанд ээлжийн амралт олгохгүй.

⁸ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.

⁹ Бүх хөрөнгө оруулалт, хөрөнгө, авлага

¹⁰ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

Дээрх байдлуудаас үндэслэн нэгэнт ӨЭМТ-ийн санхүүжилтийг төсвөөс 100 хувь олгож байгаа тохиолдолд санхүүжилтийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, батлан, зарцуулалтад төрийн сангийн хяналтыг хэрэгжүүлэх хууль, эрхийн үндэслэл, боломж бий эсэхийг судалж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Нөгөө талаас хөрөнгө, санхүүжилтийг нөхөрлөлийн нэг гишүүний үзэмжээр бус нийт гишүүд, хамт олны хяналтан дор зарцуулж, тайлагнах нөхцөлийг бүрдүүлэх, тодорхой хугацаанд хөрөнгө санхүүгийн зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналтыг хэрэгжүүлж, үйл ажиллагааг үнэлж дүгнэхдээ төсвийн хөрөнгийн зарцуулалтыг авч үзэж байх нь зүйтэй гэж дүгнэж байна.

2.2 Нягтлан бодох бүртгэлийг хууль, стандартын дагуу хөтөлж, тайлагнаж байна уу?

ӨЭМТ-үүд нь нягтлан бодох бүртгэлийг хууль, стандартын дагуу хөтөлж, тайлагнаагүй байна.

Засгийн газрын 2011 оны 364 дүгээр тогтоолоор баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 3.6-д “Санхүүгийн тайланг “Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба хяналтад байгаа байгууллагын нягтлан бодох бүртгэл” стандартын дагуу гаргаж тайлангийн нэгтгэлд хамруулна.” гэж заасны дагуу ӨЭМТ-үүд сумын санхүүгийн албанд нэгтгэл тайланг хүргүүлсэн байна.

Аудитын явцад ӨЭМТ-үүдийн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

- Мандал сумын Бату ӨЭМТ нь 472.0 мянган төгрөгийн, Баянбаг ӨЭМТ нь 220.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг, Сүхбаатар сумын Зөвлөх ӨЭМТ нь 246.0 мянган төгрөгийн, Хаданхуй ӨЭМТ 43.5 мянган төгрөгийн, Номтхан ӨЭМТ нь 241.5 мянган төгрөгийн, Эмнэх ӨЭМТ нь 60.0 мянган төгрөгийн хангамжийн материалыг шууд зардалд тайлагнасан нь Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 116-р тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх дансны үлгэрчилсэн заавар”-ын 4.7, 6.9 дэх заалтуудыг зөрчсөн байна.
- Мандал сумын Баянбаг ӨЭМТ нь оны эцэст 437.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага, Ачит ӨЭМТ нь оны эхэнд 321.3 мянган төгрөгийн, оны эцэст 89.3 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгээд санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.
- Сүхбаатар, Мандал сумын ӨЭМТ-үүд нь бараа материалын дэлгэрэнгүй тайланг стандартын дагуу гаргаж, хөтлөөгүй байгаа нь Санхүү,эдийн засгийн сайдын 2002 оны 191-р тушаалын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг хөтлөх аргачлал”-ын 6.3.2 “Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийн товчоо”-тэй нийцэхгүй байна.

Дээрхээс байдлаас үзэхэд ӨЭМТ-үүд нь тайлант онд худалдан авсан үндсэн хөрөнгө, бараа материалыг шууд зардалд бүртгэдэг, бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг нэр төрлөөр нь дэлгэрэнгүйгээр тайлагнадаггүй зэргээр нягтлан бодох бүртгэлийг хууль, стандартын дагуу хөтлөөгүй байна.

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Эрсдэлийн аудитаар дараах зөрчилд акт, албан шаардлага бичигдлээ. Үүнд:

Нэг. Төлбөрийн акт:

- ❖ Ачит ӨЭМТ-ийн дарга, их эмч О.Мөнхзулд суралцаж байх хугацаанд нь ээлжийн амралтын олговрын 460.4 мянган төгрөгийг олгосон.
- ❖ Мандал сумын ӨЭМТ-үүдийн нягтлан бодогч Н.Элбэгзаяа нь Бату ӨЭМТ-өөс 3-р сард цалингийн урьдчилгаа авч, тооцооны дансаар дамжуулж бүртгээгүйгээс жилийн эцэст 426.9 мянган төгрөг дутуу суутгасан.
- ❖ Зөвлөх ӨЭМТ нь холбооны зардалд 148.5 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн зэрэг нийт **1,035.8** мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт бичигдлээ.

Хоёр. Албан шаардлага:

- ❖ Эмнэх ӨЭМТ нь Засгийн газрын тогтоол, шийдвэрийг зөрчин, магистрийн зэргийн нэмэгдэл тооцож олгосон 1,161.9 мянган төгрөг,
- ❖ Хаданхуй ӨЭМТ нь 333.3 мянган төгрөгийн, Зөвлөх ӨЭМТ нь 850.2 мянган төгрөгийн, Номтхан ӨЭМТ нь 984.5 мянган төгрөгийн мэргэжлийн зэргийн нэмэгдлийг тус тус илүү тооцож олгосон,
- ❖ Баянбаг ӨЭМТ нь оны эцэст 437.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага, Ачит ӨЭМТ нь оны эхэнд 321.3 мянган төгрөгийн, оны эцэст 89.3 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгээд, санхүүгийн тайланд тусгаагүй зэрэг нийт **4,177.9** мянган төгрөгийн зөрчилд зөрчил арилгах албан шаардлага бичигдлээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг хууль, дүрмийн дагуу зохион байгуулаагүй байна.
2. Нөхөрлөлийн тухай хуулийн дагуу ӨЭМТ-үүд нь бүгд татан буугдах үндэслэлтэй болсон байна.
3. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2016 оны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, дүгнэлт өгөгдөөгүй байна.
4. ӨЭМТ-үүдийн санхүүжилтийг журмын дагуу төлөвлөсөн боловч төсвийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүйгээс төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан байна.
5. Нягтлан бодох бүртгэлийг хууль, стандартын дагуу хөтөлж, тайлагнаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга Ш.Оргил, ЭМГ-ын дарга Ж.Од нарт:

- ❖ Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулах.
- ❖ Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг журамд заасны дагуу үнэлж, дүгнэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

- ❖ ӨЭМТ-үүдийн санхүүжилтийг бүлгийн болон зардлын дүнгээр төлөвлөж, батлах, хянах боломж бий эсэхийг ЭМЯ болон Сангийн яаманд уламжилж, шийдвэрлүүлэх, эсвэл хөрөнгийн зарцуулалтад нөхөрлөлийн гишүүд, хамт олны хяналтыг хэрэгжүүлснээр төсвийн хөрөнгийг үр ашиг, үр нөлөөтэй зарцуулах нөхцлийг бүрдүүлэх.
- ❖ ӨЭМТ-үүдийн төсвийн гүйцэтгэлд үр нөлөө бүхий дотоод хяналтыг тогтмол гүйцэтгэж байх.

ӨЭМТ-үүдийн дарга нарт:

- ❖ Өрхийн эрүүл мэндийн төвийн шинэчилсэн дүрмийн дагуу нөхөрлөлийн гишүүдийг хамруулах ажлыг зохион байгуулах.
- ❖ Үйл ажиллагааны зардлын төсвийг нөхөрлөлийн гишүүдийн хурлаар хэлэлцэн, батлуулж байх.
- ❖ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.
- ❖ Дотоод журмыг холбогдох хууль, эрхийн актад нийцүүлэн шинэчилж, хэрэгжүүлэх, хуулиас давсан эрх мэдэл олгосон заалтуудыг өөрчлөх.

ӨЭМТ-үүдийн нягтлан бодогч нарт:

- ❖ Бараа материалын тайланг нэр төрлөөр нь гаргуулж, нярвын тайланг хянан баталгаажуулж байх.
- ❖ Батлагдсан төсөв, санхүү, хөрөнгө мөнгөний зарцуулалтад НББ-ээр тавих хяналтыг сайжруулах.
- ❖ НББ-ийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн хөтлөх.
- ❖ ХХОАТ, НДШ болон хувь хүнтэй холбоотой үүссэн авлага, өглөгийг тухай бүрд нь бүртгэж, тайлагнах, үүссэн авлага, өглөгийг барагдуулах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АУДИТОР

Ц.ОТГОНБАЯР